



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 2/111

Улаанбаатар хот

Салбарын хүүхэд хамгааллын
бодлого батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хүүхэд хамгааллын бодлогыг хавсралтаар баталсугай.
2. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж ажиллахыг салбарын бүх шатны байгууллагын удирдлагад даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга / Г.Өнөрбаяр /-т, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитийн газар /Д.Чинзориг/ -т, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар /Г.Батдорж/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД



А.АРИУНЗАЯА

• 151201586



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хүүхэд хамгааллын бодлого” /цаашид Салбарын хүүхэд хамгааллын бодлого гэх/-ыг салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллага бүр баталж, үйл ажиллагаа, үйлчилгээндээ хүүхдийн эрхийг ханган ажиллана.

1.2. Салбарын бүх шатны байгууллага нь Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын жишиг бодлого, Эцэг эхийн зөвлөл байгуулах зөвлөмж, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасны дагуу ажил, амралтын цагийг зохицуулах, ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ.

1.3. Ажилтан, албан хаагчдаараа дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалахад чиглэсэн үүрэг, хариуцлагаа биелүүлэх чиглэсэн сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж, салбарын хэмжээнд байгууллагын нөөц, онцлогт нийцүүлэн хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж ажиллана.

Хоёр. Зорилго

2.1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын байгууллага бүр ажил, үйлчилгээндээ хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, ажилтан, албан хаагчдаараа дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ээлтэй орчин бүрдүүлж ажилтан албан хаагчдын ажил амьдралын тэнцвэрийг хангахад чиглэгдэнэ.

Гурав. Хамрах хүрээ

3.1. Энэхүү баримт бичиг нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт үйл ажиллагаа явуулж буй бүх байгууллагын үндсэн болон гэрээт ажилтан, албан хаагч, сайн дурын ажилтан, дадлагажигч ажилтан, оюутан, зочид, судлаач, хамтран ажиллах байгууллага болон хувь хүмүүст хамаарна.

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

4.1. Салбарын хэмжээнд ажилтны ажил, амралтын цагийг зохицуулах, ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг зөрчсөн ажилтанд зөвлөх, зааж сургах.

4.2. Цэцэрлэгийн болон бага ангийн хүүхэдтэй ажилтан, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эх, хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай өрхийн гишүүнтэй ажилтан, өрх толгойлсон эцэг, эхийн ажиллах нөхцөлийг уян хатан болгож хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгуулж, мөрдүүлнэ. Үүнд:

4.2.1. богиносгосон цагаар ажиллах;

4.2.2. цахимаар ажиллах;

4.2.3. хүүхдээ цэцэрлэг, сургуульд хүргэж өгөх, авах боломжоор хангах;

4.2.4. шөнийн ээлжийн ажилд аль болох хуваарилахгүй байх;

4.2.5. цалингийн нэмэлт, урамшуулал дэмжлэг үзүүлэх;

4.2.6. бусад дэмжлэгт хамруулах.

4.3. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг", "Байгууллагад эцэг эхийн зөвлөл байгуулах зөвлөмж"-ийн дагуу байгууллага, аж ахуйн нэгж бүр нийгмийн хариуцлагаа ухамсарлаж хүүхэд хамгааллын асуудлаар ажиллах "Эцэг эхийн зөвлөл" /цаашид Зөвлөл гэх/-ийг байгуулах.

4.3.1 "Хүүхэд хамгааллын бодлого" -ыг хэрэгжүүлэх нийт ажилтан албан тушаалтны төлөөлөл бүхий 3-9 хүний бүрэлдэхүүнтэй "Эцэг эхийн зөвлөл" байгуулна. Энэхүү зөвлөл нь байгууллагын "Хүүхэд хамгааллын бодлого"-ыг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, харагдахуйц газар байрлуулан мөрдөж ажиллахыг сурталчилна.

4.3.2. Байгууллагын эцэг эхийн зөвлөл нь байгууллагын ажилтан, албан хаагчдын гэр бүл, хүүхдийн мэдээллийн сан бүрдүүлж, судалгаанд үндэслэн гэр бүлийн боловсрол, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааг үе шаттай төлөвлөн зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, үйлдвэрлэл, бүтээгдэхүүнээр гэр бүл, хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих талаар удирдлагатай хамтран ажиллана.

4.4. Байгууллагад болон байгууллагаас явуулж буй үйл ажиллагааны үед хүүхэд хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдалд өртөхөөс урьдчилан сэргийлэх

4.5. Тодорхой газар хүүхдийн аюулгүй байдал алдагдсан, хүүхэд хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн болон өртсөн байж болзошгүй талаар мэдээллийг Хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу холбогдох газарт мэдээлэх, мэдээлэгчийн нууцлалыг хадгалан, мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангана.

4.6. Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул заналхийлсэн нөхцөл байдал үүссэн тохиолдолд хүүхдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хангах, тухайн асуудал нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол хуулийн байгууллага болон орон нутгийн эрх бүхий хүүхэд хамгааллын байгууллага, хамтарсан багт яаралтай мэдэгдэх, хуулийн байгууллага болон орон нутгийн эрх бүхий хүүхэд хамгааллын байгууллагаас нь хэргийн явцын болон хэрхэн шийдвэрлэсэн талаарх эцсийн мэдээллийг авдаг байна.

4.7. Байгууллага бүр албан хаагчиддаа зориулж сургалт, нөлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Үүнд:

4.7.1 Ажилтан, албан хаагчийн хүүхдийн сурч боловсрох, хөгжил, хамгааллыг дэмжих;

4.7.2. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, ажилтан, албан хаагч, тэдний гэр бүл, хүүхдэд зориулсан соён гэгээрүүлэх, хөгжүүлэх, чадавхжуулах сургалт, сэтгэл зүйн зөвлөгөөнд хамруулах.

4.8. Байгууллага бүр өөрийн боломж, ажилтнуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн санал санаачилгыг өрнүүлж байгууллагын нөөцөд тулгуурлан хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ. Тухайлбал:

4.8.1. хүүхдийн хөгжих, эрүүл аюулгүй орчин бүрдүүлж, хараа хяналттай байхад анхаарч, байгууллагын дэргэдэх цэцэрлэг, өдөр өнжүүлэх төв, хүүхдийн өрөө байгуулах санал санаачилгыг өрнүүлж, зохион байгуулах;

4.8.2. байгууллагын гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээ хийх, илэрсэн эрсдэлийг арилгах арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулах;

4.8.3. жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй ажилтан, нярай болон бага насны хүүхэдтэй үйлчлүүлэгчид ээлтэй, таатай орчин бүрдүүлж, хүүхэд хөхүүлэх, хуурайлах /живх солих/, хооллох, амрах өрөө бэлтгэх;

4.8.4. байгууллагын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, үйлчилгээ нь хүүхдэд хор хөнөөл учруулж болзошгүй эрсдэл байгаа эсэхэд тогтмол үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах, арилгахад анхаарч ажиллана.

Тав. Ажилтан шалгаруулан ажилд авахад дараах асуудлыг анхаарах

5.1. Хүүхдэд хор хохирол учруулж болзошгүй хүнийг ажилд авахаас урьдчилан сэргийлэхийн тулд хүүхэдтэй зүй бусаар харилцаж байсан эсэхийг ажилтан шалгаруулах үзүүлэлтэд оруулах, ажилд шинээр авах гэж буй хүний тухай эрх бүхий байгууллагаас хүүхдийн эрхийн зөрчил гаргаж байсан эсэх талаар тодорхойлолт авна.

Зургаа. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм

6.1. Ёс зүйн дүрмийн гол зорилго нь байгууллагын ажилтны зүгээс хүүхэд хамгааллын хувьд эрсдэлтэй, зохисгүй зан үйл гаргахгүй байхад чиглэнэ.

Ажилтны ёс зүйн хувьд хориглох зүйл	<ul style="list-style-type: none"><input checked="" type="checkbox"/> Хүүхдийг цохих, зодох, тусгаарлах зэргээр бие махбодын хүчирхийлэл үйлдэх<input checked="" type="checkbox"/> Хүүхдийг гутаах, ичээх, доромжлох, дорд үзэх, нэр хоч өгөх, сэтгэл зүйн дарамт учруулах зэргээр сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх<input checked="" type="checkbox"/> Хүүхэдтэй бэлгийн харилцаанд орох, бэлгийн харилцаанд уруу татах, биеийг үнэлүүлэх зэргээр бэлгийн хүчирхийлэл үйлдэх<input checked="" type="checkbox"/> Хүүхдийг бэлгийн харилцаанд өдсөн, садар самуунд уруу татсан тоглоом тоглох, шалиг үг яриа ярих зэргээр биеэ авч явах, бусдад тийм боломж олгох<input checked="" type="checkbox"/> Хууль бус эсвэл хүүхдэд аюултай нөхцөл байдалд орсон тохиолдолд түүнийг тоохгүй орхих<input checked="" type="checkbox"/> Хүүхдийн дэргэд хараал хэлэх, бүдүүлэг үг хэрэглэх<input checked="" type="checkbox"/> Хүүхдийг ямар нэг байдлаар нь ялгаварлан харилцах<input checked="" type="checkbox"/> Бусад ажилтан албан хаагчидтай дээрэнгүй, зандарч харилцах, хүүхдийн өмнө зүй бус хараалын үг хэрэглэх
-------------------------------------	---